



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 81/478

Алтай хот

**Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийг батламжлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10 дахь заалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.30 дахь хэсэг, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/334 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшиж сонгогдсон дараах гишүүдийг батламжилсугай. Үүнд:

а/. Өмчлөгчийг төлөөлөх:

- Х.Баатарзориг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга) 6 жилээр
- Т.Ганболд (Аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн) 6 жилээр
- Б.Энхцэцэг (Аймгийн Эрүүл мэнд даатгалын хэлтсийн дарга) 6 жилээр

б/. Нэгдсэн эмнэлгийн хамт олны төлөөлөл:

- Б.Батсүрэн (Нэгдсэн эмнэлгийн Мэдээгүйжүүлэлт эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, их эмч) 6 жилээр
- Л.Энхжаргал (Нэгдсэн эмнэлгийн Гэмтлийн тасгийн ахлах сувилагч) 3 жилээр
- Г.Оюун (Нэгдсэн эмнэлгийн хүний нөөцийн мэргэжилтэн) 3 жилээр

в/. Олон нийтийг төлөөлөх төлөөлөл:

- Б.Батнасан (Мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөлөл) 6 жилээр
- А.Шийрэвнямба (Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл) 3 жилээр
- С.Галсанчоймбол (Даатгуулагчийн олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагын төлөөлөл) 3 жилээр


2.Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн эрх, үүргийг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй хэрэгжүүлж, Нэгдсэн эмнэлгийн үйл

2.

ажиллагааг сайжруулж, менежментийн сайн туршлагыг нэвтрүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэн ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

3.Төлөөлөн удирдах зөвлөлийн захиргааны үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат), Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР